



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/416

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.9, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Гишүүнчлэлийн журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1.2.2, 7.4 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Ди эйч капитал ҮЦК" ХХК болон "Масдак ҮЦК" ХХК-ууд нь Гишүүнчлэлийн журам болон Гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн гишүүнчлэлийн хөлс төлөх, арилжааны системд нэвтрэх эрхийн хураамж төлөх үүргээ биелүүлээгүй тул 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлсүгэй.
2. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т тус тус даалгасугай.
3. Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлсэн компанийн талаарх холбогдох мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Монголын үнэт цаасны клирингийн төвд тус тус мэдэгдсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын албаны мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДӨЛГӨӨН

1525030863